



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 43,900,000.00 (дөчин гурван сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 30,729,999.72 (гучин сая долоон зуун хорин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Увс-А33А” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, “Увс-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Цэдэнбал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 01
дүгээр сарын 22-ний өдрийн 22.
дугаар тогтоолын хавсралт

**Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй "Увс-А33А" ТӨХК-д балансад
шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	тоо шир хэг	Балансын үнэ/төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл/төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Хьюндай маркийн 04-41 УБҮ улсын дугаартай, суудлын автомашин, КМНЕВ41СВЕА639642- арлын дугаар	2014	1	43,900,000.00	30,729,999.72	13,170,000.28
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)	43,900,000.00 (дөчин гурван сая есөн зуун мянган)	30,729,999.72 (гучин сая долоон зуун хорин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг далан хоёр мөнгө)	13,170,000.28 (арван гурван сая нэг зуун далан төгрөг мянга хорин найман мөнгө)